

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	10
2.10	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар,.....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3.	Менежментийн захидал.....	12
3.1	Балансын данстай холбоотой асуудал.....	12
3.2	Балансын данстай холбоотой асуудал.....	12
3.3	Дотоод хяналт	13
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.АМАРСАНАА ТАНАА

2018.03.15 № 06/496
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус ТӨААТҮГ-ын захирал Ц.Амарсанаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн өглөг, авлагын данстай холбоотой болон дотоод хяналтын талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 15-наас 2019 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Энхжин хариуцаж хэрэгжүүлэв.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 628 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь, нийтийн аж ахуйн талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах, УИХ, Засгийн газраас баталсан улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд техникийн хяналтад тавих, магадлал хийх ажлыг зохион байгуулах, шаардлагатай судалгаа мэдээллээр Барилга, хот байгуулалтын яамыг хангах зорилго бүхий Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилго нь Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтыг тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, барилгын салбарын талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахад оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын төсөв болон гадаад, дотоодын санхүүжилтээр хот байгуулалт, барилгын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх,

- Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах ажлыг зохион байгуулах,
- Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалтын ажлыг зохион байгуулах,
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах,
- Барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах,
- Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйг салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах,
- Барилга, байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индексийг боловсруулах,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох,
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох ажлыг зохион байгуулах,
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх,
- Барилга, байгууламжийн норм, нормативын санг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах,
- Архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг зохион байгуулах,
- Барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж баталгаажуулах ажлыг зохион байгуулах,
- Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцийн бодлого зорилтыг сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх,
- Барилга, нийтийн аж ахуйн салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Барилгын тухай хууль
- Орон сууцны тухай хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Компанийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив Би Ай” ХХК-ийн Diamond програм хангамж ашигладаг байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд

үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 5,525.0 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 55.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөг үнэлэхэд дотоод хяналт сул байгаа тул эрсдэл ихтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав.

Аудитын явцад санхүүгийн тайланд нийт 1,850.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан болно. Үүнд:

- 2018 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг 2017 оны аудит хийсэн санхүүгийн тайлантай тохирч байгаа боловч 2017 оны ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн эргэлтийн бус хөрөнгийн дүн 845.6 сая төгрөгөөр зөрүүтэй,
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 272 дугаар тогтоолоор БХТ-ийн балансаас БХБЯ-ны балансд 2,138.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гарч, БХБЯ шилжиж ирсэн хөрөнгийн үлдэх өртөг 1,004.4 сая төгрөгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн боловч, БХТ нь санхүүгийн тайландаа хөрөнгө данснаас хассаны гарзаар бүртгээгүй зэрэг зөрчлийг аудитын явцад илрүүлж санхүүгийн тайланд залруулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/сая төгрөгөөр/				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	54.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	289.5	
3	Албан шаардлага өгсөн	1	1,009.2	
	Дүн	6	1,353.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. БХТ нь сангийн хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлттэй холбоотой орлого, зардлыг анхан шатны баримт бичиг болон нягтлан бодох бүртгэлд орлого, зардлаар тусгаагүй, мөн Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор зарим чиг үүргийг БХТ ТӨААТҮГ-т шилжүүлсэн боловч Барилгын тухай хуульд заасан "Барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах" чиг үүргийг БХТ-д шилжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Норм, нормативын сангийн 2018 оны жилийн эцсийн дансны үлдэгдэл 1,015.9 сая төгрөг байна. Тус сангийн 2019 оны орлогын төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг 726.4 сая төгрөгөөр баталсан байна. 2018 оны үлдэгдлээс 2019 онд санхүүжих дүнгийн зөрүү 289.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Барилгын хөгжлийн төвийн 2018 оны оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гадаад томилолт болон бараа материалыг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар,

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 650 дугаар тогтоолоор орлогын төлөвлөгөөг 4,642.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,476.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Тайлант онд нийт 6,027.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 1,384.4 сая төгрөгөөр давуулан биелүүлж, нийт зардалд 4,572.8 сая төгрөгийг зарцуулж төлөвлөгөөг 96.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь shilendans.gov.mn цахим хуудсанд батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллүүд, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, бусад цэсэд байрлуулсан мэдээллийг оруулж байна. Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 60 хувьтай байгаа нь Барилга, хот байгуулалтын сайдын тушаалуудын холбогдох заалтууд нь ТӨБЗГ-ын тогтоол шийдвэртэй зөрчилдөж байгаа тул төсөв хөрөнгийн талаарх оновчтой шийдвэрийг гаргуулах арга хэмжээ авч ажиллах, “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн түрээсийн төлбөрийг бүрэн төлж, өр барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар өгөгдсөн зөвлөмжүүдийг биелүүлээгүйтэй холбоотой байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох САГ-2019/31/СТА-ТӨААТҮГ

хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд нийт 49.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоон мэдээлэл буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгөгдсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн болно.

3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт:

Авлагын дэлгэрэнгүй журналаас авлагын үлдэгдэлтэй харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актыг тулган шалгахад 4.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоон мэдээлэл буруу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгөгдсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн болно.

3.3 Дотоод хяналт

3.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд бэлэн мөнгөөр бараа материал борлуулсны орлогыг банкин дахь харилцах дансанд тушаагаагүй, байгууллагын үйл ажиллагааны шууд зардалд зарцуулсан байна.

3.3.2 Эрсдэл:

Бэлэн мөнгө дутах эрсдэлтэй байна.

3.3.3 Өгөгдсөн зөвлөмж:

БХТ-ийн захирлын 2012 оны 140 дугаар тогтоолоор баталсан кассын үйл ажиллагааны журмын 2.8-д "Кассын нярав нь кассын үлдэгдлийг ажлын 2 хоног тутамд банкин дахь банкинд дахь харилцах дансанд тушааж байх ба шаардлагатай тохиолдолд тухайн өдөрт нь тушааж байна" гэж заасныг мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах, орлогын гүйлгээг цахим хэлбэрт шилжүүлж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	9,848,827,734.45	13,362,268,214.04
1.1	Эргэлтийн хөрөнгө	4,788,870,753.36	7,304,994,887.47
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,599,391,806.42	7,096,387,479.20
1.1.2	Дансны авлага	34,154,555.03	26,715,637.31
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	5,969,200.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	155,324,391.91	175,922,570.96
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,788,870,753.36	7,304,994,887.47
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,989,661,044.92	5,083,859,968.80
1.2.2	Биет бус хөрөнгө	70,295,936.17	973,413,357.77
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,059,956,981.09	6,057,273,326.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,848,827,734.45	13,362,268,214.04
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	1,048,431,134.97	1,732,262,444.75
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	54,574,711.99	41,845,511.71
2.1.1.4	НДШ-ийн өглөг	942,719.19	2,019,909.36
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	42,406,400.00	42,344,400.00
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,142,635,663.96	1,776,412,124.60
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,288,990,630.11	3,594,884,390.42
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,288,990,630.11	3,594,884,390.42
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	8,159,338.00	8,159,338.00
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	195,479,515.00	195,479,515.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	1,067,439,884.99
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,553,814,718.45	6,454,791,998.45
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,802,383,532.89	2,041,513,087.18
2.3.20	Эздийн өмчийн дүн	7,559,837,104.34	9,767,383,823.62
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	9,848,827,734.45	13,362,268,214.04

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,361,884,764.95	5,729,895,019.80
2	Борлуулалтын өртөг	28,725,860.61	59,931,943.13
3	Нийт ашиг (алдагдал)	4,333,158,904.34	5,669,963,076.67
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	177,073,144.35	165,272,652.02
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	128,993,783.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,976,116,323.88	4,512,942,487.27
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	2,448,940.00	7,596,829.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-516,194.61	2,974,141.48
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	- 1,004,462,884.15
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	531,150,590.20	442,201,452.75
19	Орлогын татварын зардал	53,115,059.01	60,747,410.46
20	Татварын дараах ашиг (алдагдал)	478,035,531.19	381,454,042.29
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	478,035,531.19	381,454,042.29
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	478,035,531.19	381,454,042.29
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-478,035,531.19	-381,454,042.29

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/							
	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	0.00	5,594,406,006.64	1,359,433,656.10	7,157,478,515.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	0.00	5,594,406,006.64	1,359,433,656.10	7,157,478,515.74
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	-40,591,288.19	-35,085,654.40	-75,676,942.59
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	478,035,531.19	478,035,531.19
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	0.00	5,553,814,718.45	1,802,383,532.89	7,559,837,104.34
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	0.00	5,553,814,718.45	1,802,383,532.89	7,559,837,104.34
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	900,977,280.00	-142,324,488.00	-142,324,488.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	381,454,042.29	381,454,042.29
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	1,067,439,884.99	0.00	0.00	1,067,439,884.99
17	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,067,439,884.99	6,454,791,998.45	2,041,513,087.18	9,767,383,823.62

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайланТайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,309,310,577.63	10,996,421,542.09
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	6,148,636,570.67	9,418,516,114.35
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,160,674,006.96	1,577,905,427.74
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-5,832,802,446.46	-8,443,232,927.81
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-1,610,946,648.84	-2,028,226,578.48
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-654,473,229.67	-953,897,748.07
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-2,657,945,125.86	-3,890,231,254.24
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-41,381,304.88	-70,951,348.27
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-12,216,447.03	-219,156,012.97
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-342,800,208.57	-525,188,533.01
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-3,289,530.00	-4,858,630.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-509,749,951.61	-750,722,822.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,476,508,131.17	2,553,188,614.28
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	177,073,144.35	165,272,652.02
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	177,073,144.35	165,272,652.02
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-190,845,816.04	-224,439,735.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-190,845,816.04	-224,439,735.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-13,772,671.69	-59,167,082.98
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,203,259.21	3,231,798.43
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00

3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	1,203,259.21	3,231,798.43
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-1,719,453.82	-257,656.95
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-1,719,453.82	-257,656.95
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-516,194.61	2,974,141.48
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,462,219,264.87	2,496,995,672.78
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,137,172,541.55	4,599,391,806.42
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,599,391,806.42	7,096,387,479.20

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2018 он	Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2019/31/СТА-ТӨААТҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	БХТ нь сангийн хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлттэй холбоотой орлого, зардлыг анхан шатны баримт бичиг болон нягтлан бодох бүртгэлд орлого, зардлаар тусгаагүй, мөн Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор зарим чиг үүргийг БХТ ТӨААТҮГ-т шилжүүлсэн боловч Барилгын тухай хуульд заасан "Барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах" чиг үүргийг БХТ-д шилжүүлээгүй байна.	1,009.2	Албан шаардлага өгөх	Захирал	Ц.Амарсанаа
				СТХХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Гантуул
2	Норм, нормативын сангийн 2018 оны жилийн эцсийн дансны үлдэгдэл 1,015.9 сая төгрөг байна. Тус сангийн 2019 оны орлогын төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг 726.4 сая төгрөгөөр баталсан байна. 2018 оны үлдэгдлээс 2019 онд санхүүжих дүнгийн зөрүү 289.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх.	289.5	Төлбөрийн акт тогтоох	Захирал	Ц.Амарсанаа
				СТХХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Гантуул
3	Тайлант онд нийт 49.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	49.8	Зөвлөмж өгөх	Захирал	Ц.Амарсанаа
				СТХХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Гантуул
4	Авлагын дэлгэрэнгүй журналаас авлагын үлдэгдэлтэй харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актыг тулган шалгахад 4.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	4.6	Зөвлөмж өгөх	Захирал	Ц.Амарсанаа
				СТХХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Гантуул
5	Тайлант онд бэлэн мөнгөөр бараа материал борлуулсны орлогыг банкин дахь харилцах дансанд тушаагаагүй, байгууллагын үйл ажиллагааны шууд зардалд зарцуулсан байна.		Зөвлөмж өгөх	Захирал	Ц.Амарсанаа
				СТХХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Гантуул
Нийт дүн		1,353.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 03 дугаар сарын 21

№ 03/118

Улаанбаатар хот

С.т.г. 2019/31/СТА-ТӨААТҮГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагаагаа явуулж, тайлант онд нийт 1,832.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 823.3 сая төгрөгийг сангийн үйл ажиллагаанд зарцуулж 1,009.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Барилга, хот байгуулалтын яаманд өгөх өглөгөөр бүртгэсэн байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь сангийн хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлттэй холбоотой орлого, зардлын гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон санхүүгийн тайланд орлого, зардлаар тусгаагүй байна. Мөн Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор зарим чиг үүргийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т шилжүүлсэн боловч Барилгын тухай хуульд заасан "Барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах" чиг үүргийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т шилжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.12-т "Барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах", 34.2-т "Энэ хуулийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.14, 34.1.15-д заасан чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно", Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолын 1-т "Барилгын тухай хуулийн 34.1.2, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.15-д заасан барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг "Барилгын хөгжлийн төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд зөвшөөрсүгэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2019\0321SAG2.Docx

070507

1. Норм, нормативын сангийн хөрөнгийг Барилга, хот байгуулалтын яаманд шилжүүлж 2019 оны 4 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилгын хөгжлийн төвийн ТӨААТҮГ-ын Захирал Ц.Амарсанаа, Санхүү төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч Г.Гантуул нарт даалгав.
2. Дээрх зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах.

АЛБАН ШААРДЛАГЫГ

өгсөн:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН
 ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТОР
 Б.ЭНХЖИН

ЗӨВШӨӨРСӨН:
 БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ
 ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
 Ц.АМАРСАНАА
 САНХҮҮ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН
 ХЭЛТСИЙН ДАРГА ЕРӨНХИЙ
 НЯГТЛАН БОДОГЧ
 Г.ГАНТУУЛ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 03 дугаар сарын 21

№ 03/49

Улаанбаатар хот

САГ-2018/31/СТА-ТӨААТҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Норм, нормативын сангийн 2018 оны жилийн эцсийн дансны үлдэгдэл 1,015,971,906.20 төгрөг байна. Тус сангийн 2019 оны орлогын төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг 726,422,495.00 төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Норм, нормативын сангийн 2018 оны үлдэгдлээс 2019 онд санхүүжих дүнгийн зөрүү 289,549,411.20 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх.
2. Биелэлтийг 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын Захирал Ц.Амарсанаа, Санхүү төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Гантуул нарт даалгав.

АКТЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ц.Наранчимэг*
АУДИТОР *Б.Энхжин*

ХА9122

ЗӨВШӨӨРСӨН:

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ *Ц.Амарсанаа*
САНХҮҮ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ *Г.Гантуул*

ТТА7992 + 5164753

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харилцагч албан тушаалтанд харилцаага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2019\0321SAG1.Docx

070140

